



Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АУДИТЫН КОД: ХЭА-2024/26-21-ШТА-ГА

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР
ДҮН, ҮР НӨЛӨӨ”-д хийсэн ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2024 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар

Утас: 7056-2112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 9977-5390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 8803-2817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Б.Хуланхатан

Утас: 9900-8827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn

Аудитор Н.Туяа

Утас: 9979-9709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	5
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	6
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ.....	7
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛИЙН ДАГУУ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	10
1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй, орон нутгийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлээгүй байна.	10
1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн боловч иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг ИТХ-аар баталж, хэрэгжүүлсэн байна.....	11
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭГ 77.0 ХУВЬТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН Ч ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	14
2.1. Баталгаажсан гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгож байгаа хэдий ч гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тохиолдолд алдангийг тооцохгүй байна.	14
2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бага дүнтэй, хэт олон ажилд зарцуулсан нь үр дүнгүй байна.	15
2.3. Төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.	17
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ АЖЛЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	19
3.1. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд аймаг, сумын ИТХ болон захиргааны байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.	19
3.2. ОНХС-ийн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, журмын дагуу иж бүрэн тайлагнах, иргэд, олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх шаардлагатай байна.	22
ИРГЭДЭЭС АВСАН САНАЛЫН ТАЛААР	25
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	27
ДҮГНЭЛТ:	28
ЗӨВЛӨМЖ:	29



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон Улсын байгууллага
СХДАА	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгтийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХНС -ийн эх үүсвэр	10
Хүснэгт 2	ОНХС -ийн эх үүсвэр	11
Хүснэгт 3	ОНХНС -ийн саналын тоо	11-12
Хүснэгт 4	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн чиг үүргийн жагсаалт	13
Хүснэгт 5	Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	14
Хүснэгт 6	Санал асуулгын дүн 1	21
Хүснэгт 7	Санал асуулгын дүн 2	25



ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэлийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын эх үүсвэр	9
Дүрслэл 2	Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй ТАХ-ний тоо	20
Дүрслэл 3	Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл оруулаагүй ТАХ-ний тоо	24



ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралтын дугаар	Тайлбар
Хавсралт 1	Хэнтий аймгийн ОНХС-ийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт
Хавсралт 2	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа
Хавсралт 3	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ
Хавсралт 4	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ашиглалт, үр дүн
Хавсралт 5	Хэнтий аймгийн 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналт
Хавсралт 6	Хэнтий аймгийн ОНХС-ийн 2023 оны аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт
Хавсралт 7	ОНХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт
Хавсралт 8	Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чиг үүргийн нийцлийн байдлын судалгаа
Хавсралт 9	Хэнтий аймгийн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хууль журамд заасан чиг үүргийн нийцлийн судалгаа
Хавсралт 10	Хэнтий аймгийн 2023 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний иргэдийн саналын судалгаа
Хавсралт 11	Хэнтий аймгийн 2023 оны ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийн гүйцэтгэл
Хавсралт 12	Хэнтий аймгийн, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг данс бүртгэлийн судалгаа



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Сангийн яам, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, багийн Засаг дарга, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, 6817-8:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын зарчмын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
 - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
 - Төсвийн тухай хууль;
 - Төрийн хэмнэлтийн тухай хууль;
 - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- “Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх заалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг баталж, аймаг, сумын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоожээ.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Хэнтий аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 11,714.8 сая төгрөг, "Тогтвортой амьжиргаа-3" төслөөс 736.4 сая төгрөгийг баталсан бол малын тоо толгойн албан татварын 1,460.3 сая төгрөг, аймаг, сумдын ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 1,860.0 сая төгрөг, нийт 15,771.5 сая төгрөг болгон төлөвлөсөн байна.

Дүрслэл 1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын эх үүсвэр



Тайлант хугацаанд ОНХНС-аас орлогын шилжүүлгийг 285.1 сая төгрөгөөр дутуу олгосон, малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 214.4 сая төгрөгөөр тасарснаас аймгийн ОНХС-д нийт 13,412.0 сая төгрөг төвлөрсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 18,912.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15,766.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 278 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс аймгийн ИТХ-ын тогтоолоор 9,361.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 37 төсөл, арга хэмжээ, сумдын ИТХ-ын тогтоолоор 9,551.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 241 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

Баталсан 278 төсөл, арга хэмжээнээс 216 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 12,793.9 сая төгрөгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Гэрээ байгуулаагүй, хэрэгжээгүй 39, өмнөх оноос дамжин хэрэгжих 21 төсөл, арга хэмжээ байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 16,612.8 сая төгрөгөөр ажил, бараа, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан 239 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс 237 төсөл, арга хэмжээнд нийт 13,759.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.



БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛИЙН ДАГУУ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй, орон нутгийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлээгүй байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд улсын төсвөөс Хэнтий аймагт ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 10,112.4 сая төгрөгөөр баталж, 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 2,338.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 12,451.2 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийн 56.4 хувь буюу 7,026.8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 43.6 хувь буюу 5,424.4 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

Гүйцэтгэлээр ОНХНС -аас орлогын шилжүүлэгт 12,166.2 сая төгрөг олгож 285.1 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Үүнд: ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгийг 209.4 сая төгрөгөөр, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 75.7 сая төгрөгөөр тус тус дутуу олгосон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. ОНХНС -ийн эх үүсвэр

/сая төгрөгөөр/

2023 оны ОНХНС болон улсын төсөв					
Үзүүлэлт	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр		"Тогтвортой амжиргаа-3" төсөл урамшуулал	Нийт
		Хайгуул 100%	Ашиглалт 50%		
Төлөвлөгөө	10,941.6	319.1	454.1	736.4	12,451.2
Гүйцэтгэл	10,732.2	319.1	378.4	736.4	12,166.2
Зөрүү	209.4	-	75.7	-	285.1

Төсвийн тухай хуулийн 59.3 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу Сангийн яамнаас тооцоолж ирүүлсэн хуваарийг үндэслэн аймгийн СТСХ-ээс орлогын шилжүүлгийг сумдад хуваарилсан байна.

Аймгийн ОНХС-аас 22 сум, тосгонд олгох орлогын шилжүүлэг 5,424.4 сая төгрөгийг бүрэн олгосон ч ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 2023 оны 3, 4, 5, 7, 9, 10 дугаар саруудад хуваарийн дагуу санхүүжүүлээгүйгээс шалтгаалж, сумдын ОНХС-д орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

Санхүүжилт хуваарийн дагуу цаг хугацаандаа олгогдоогүй нь сангийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлээгүйтэй холбоотой байна.

Орон нутагт дараах орлогуудыг төлөвлөхөөс зөвхөн малын тоо толгойн албан татварын орлогыг 1,460.3 сая төгрөгөөр төлөвлөж, 1,245.9 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 214.4 сая төгрөг буюу 14.7 хувиар дутуу биелүүлсэн байна.



Хүснэгт 2. ОНХС -ийн эх үүсвэр

/сая төгрөгөөр/

2023 оны Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр					
Үзүүлэлт	ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"	ТТХ-ийн 60.2.5 "тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"	ТТХ-ийн 60.2.9."Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж".	Малын тоо толгойн албан татвар	Нийт
Төлөвлөгөө	-	-	-	1,460.3	1,460.3
Гүйцэтгэл	-	-	-	1,245.9	1,245.9
Зөрүү	-	-	-	214.4	214.4

Малын тоо толгойн албан татварыг Батноров сум 75.3 сая, Баян-Адарга сум 16.1 сая, Баянмөнх сум 4.2 сая, Баянхутаг сум 7.0 сая, Бор-Өндөр сум 4.5 сая, Галшар сум 45.9 сая, Дадал сум 4.9 сая, Дархан сум 3.7сая, Дэлгэрхаан сум 29.8 сая, Мөрөн сум 13.4, Өмнөдэлгэр сум 62.1, Цэнхэрмандал сум 53.2 сая, Гурванбаян тосгон 2.3 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь 2023 оны хавар, намрын байгалийн гамшигт үзэгдэлд мал ихээр хорогдож, зуд болсонтой холбоотой байна.

Аймаг, сумын ОНХС-д Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9 "Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж"-д заасан эх үүсвэрийг нэмж төлөвлөөгүй байна.

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээр 2023 оны байдлаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг 89, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг 131 нийт 220 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна. Үүнээс 16 аж ахуйн нэгжтэй Аймгийн Засаг дарга болон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явагдаж байгаа сумдын Засаг дарга нар хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн боловч иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг ИТХ-аар баталж, хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө 19 сум, 3 тосгоны 1208 иргэнээс цахимаар, 1,487 иргэнээс бүлгийн ярилцлагаар, 15,322 иргэнээс саналын хуудсаар, нийт 18,017 иргэнээс санал авсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. ОНХС -ийн саналын тоо

№	Сумын нэр	Санал өгөх хүний тоо	Санал өгсөн	Хувь
1	Галшар	1398	1163	83.2
2	Баянхутаг	1664	371	22.3
3	Баянмөнх	1037	397	38.3



4	Дархан	1389	754	54.3
5	Дэлгэрхаан	1345	492	36.6
6	Жаргалтхаан	1331	505	37.9
7	Цэнхэрмандал	1477	733	49.6
8	Өмнөдэлгэр	3094	632	20.4
9	Батширээт	1655	402	24.3
10	Биндэр	2678	867	32.4
11	Баян-Адарга	768	186	24.2
12	Дадал	1637	631	38.5
13	Норовлин	1693	1266	74.8
14	Батноров	2111	718	34.0
15	Баян-Овоо	1256	1176	93.6
16	Мөрөн	1259	880	69.9
17	Хэрлэн	13511	4221	31.2
18	Гурванбаян	634	31	4.9
19	Өлзийт	672	80	11.9
20	Бор-Өндөр	5617	2194	39.1
21	Бэрх	1270	232	18.3
22	Хэрлэнбаян-Улаан	374	86	23.0
	Нийт	47870	18017	37.6

Дээрх хүснэгтээс харахад нийт санал өгөх иргэдийн 37.6 хувь нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санал өгсөн байна. Иргэдийн өгсөн саналд үндэслэн 26,430.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 416 төсөл арга хэмжээг эрэмбэлэн сумдын ИТХ-ын хуралд өргөн барьсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь сумдаас ирүүлсэн төсөл арга хэмжээний саналд үндэслэн төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг “Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймаг, сумдын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хэнтий аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 278 төсөл арга хэмжээг 18,912.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд үүнээс өмнөх оноос шилжсэн 5,565.4 сая төгрөгийн 37 төсөл арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 13,347.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 241 төсөл арга хэмжээ байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээс санал авч, ажлын хэсгээр эрэмбэлэгдээгүй 418.9 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг аймаг, сумын ИТХ-аар батлуулж, 388.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ" гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Аймгийн ОНХС:

- “Хишгийн уулзварын гэрлэн дохио” 60.0 сая төгрөг;
- Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбайн ус зайлуулах суваг 298.9 сая төгрөг;



- Монгол хатадын өргөөний ариун цэврийн байгууламжийн шугам сүлжээний ажил 15.0 сая төгрөг;

Баянхутаг сумын ОНХС:

- Малын үзлэг ангилалтын зардал 4.0 сая төгрөг;
- Соёлын төвийг засварлах зардал 5.0 сая төгрөг;
- Тэрбум мод төсөл хэрэгжүүлэх 6.0 сая төгрөг байна.

Төсвийн тухай хуульд заасны дагуу иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлээгүй төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчлийг арилгах албан шаардлагыг Аймгийн Засаг дарга болон Баянхутаг сумын Засаг даргад хүргүүлэв.

ОНХС-ийн эх үүсвэрээс 2023 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 18,912.4 сая төгрөгийн 278 төсөл, арга хэмжээний 16,594.4 сая төгрөгийн 172 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр, 2,137.4 сая төгрөгийн 102 төсөл арга хэмжээг сумдын ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэхээр Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын чиг үүрэгт нийцүүлсэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. *Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн чиг үүргийн жагсаалт*
сая.төгрөг

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэг		Тоо	Төсөвт өртөг	Эзлэх хувь
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх		172	16,594,544.2	
4.2.1, 4.4.1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэх ухаан, цахим технологи	41	3,391,805.4	17.9
4.2.2, 4.4.2	Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	42	4,119,943.0	21.8
4.2.3, 4.4.3	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	67	8,042,666.5	42.5
4.4.4	Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	11	632,076.5	3.3
4.2.5, 4.4.5	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах	9	278,052.8	1.5
4.4.6	Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	2	130,000.0	0.7
Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хэрэгжүүлэх		102	2,138,442.3	
4.5.1	Бэлчээрийн менежментийг сайжруулах	1	40,000.0	0.2
4.5.2	Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/	23	543,916.3	2.9
4.5.3	Малын эрүүл мэндийг хамгаалах	25	497,483.6	2.6
4.5.4	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;	16	321,073.3	1.7
4.5.5	Малын чанарыг сайжруулах;	10	139,800.0	0.7
4.5.6	Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;	4	68,283.0	0.4
4.5.8	Малын тэжээлийн ургамал тариалах;	1	63,000.0	0.3
4.5.9	Тэжээлийн нөөц бүрдүүлэх;	6	301,292.7	1.6
4.5.10	Байгаль орчныг хамгаалах;	1	19,950.0	0.1
4.5.11	Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;	6	74,600.0	0.4



4.5.12	Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.	9	69,043.4	0.4
Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй		4	179,400.0	0.9
Нийт дүн		278	18,912,386.5	100.0

Журмын чиг үүрэгт нийцэхгүй 179.4 сая төгрөгийн 4 арга хэмжээг батлан хэрэгжүүлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

➤ *Мал тооллогын зардал хүрэлцээгүй шалтгаанаар "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын чиг үүрэгт байхгүй мал тооллогын зардалд Дархан сум 8.0 сая, Өмнөдэлгэр сум 5.0 сая төгрөг;*

➤ *ЗДТГ дулаан гаражгүй тул өвлийн улиралд ундны ус түгээх машин асахгүй байдаг тул иргэд санал өгсөн гэх шалтгаанаар журмын 4.4-т заасан чиг үүрэгт нийцэхгүй, "Дулаан гараж барих" зардалд 96.4 сая төгрөг, 4.5-д заасан чиг үүрэгт нийцэхгүй малын тоо толгойн албан татварын орлогоор "Жаргалантын голд гүүр барих" ажилд 70.0 сая төгрөг, нийт 179.4 сая төгрөг;*

Энэ нь Сангийн сайдын 2021 ны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.4-т "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 4.5-д "Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 4.6-д "ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй.", 4.6.1-д "Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор" гэсэн заалттай нийцэхгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлж төсвийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг арилгах албан шаардлагыг дээрх сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭГ 77.0 ХУВЬТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН Ч ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1. Баталгаажсан гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгож байгаа хэдий ч гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тохиолдолд алдангийг тооцохгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /хуучин/ дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 278 төсөл, арга хэмжээнээс 216 ажилд худалдан авах ажиллагааг зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллажээ. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 30, тендер шалгаруулалтын онцгой журам харьцуулалтын аргаар 87, гэрээ шууд байгуулах аргаар 98, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар дагуу 1 тендерийг зохион байгуулсан байна.

Үлдсэн 62 төсөл арга хэмжээний 24 төсөл, арга хэмжээ нь өмнөх онд худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулсан бол 38 нь худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохион байгуулсан ч төсөвт өртөг хүрэхгүй шалтгаанаар оролцогч ороогүй төсөл, арга хэмжээнүүд байна.



Худалдан авах ажиллагааг 54 ажлын даалгавар, 85 техникийн тодорхойлолт, 78 зураг төслийг үндэслэн зохион байгуулсан байна.

Зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны төрлөөр ангилж үзвэл ажил гүйцэтгэх 168, бараа нийлүүлэх 47, зөвлөх үйлчилгээ үзүүлэх 1 төсөл, арга хэмжээ байна.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн Төрийн сан дахь дансны эхний үлдэгдэл 2,453.2 сая төгрөг, 2023 онд 13,412.0 сая төгрөгийн орлого орж, 13,759.3 сая төгрөгийн зарлага гарсан байна. 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар дансны үлдэгдэл 2,105.9 сая төгрөг байна.

Аудитад хамрагдах төсөл, арга хэмжээнд ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх нийт 16,612.8 сая төгрөгийн 239 гэрээ байгуулсан байна. Эдгээр гэрээг хэрэгжүүлж эхэлсэн хугацаагаар авч үзвэл 2019 онд 20.0 сая төгрөгийн 1 гэрээ, 2020 онд 97.1 сая төгрөгийн 1 гэрээ, 2021 онд 130.2 сая төгрөгийн 2 гэрээ, 2022 онд 4,087.2 сая төгрөгийн 19 гэрээ, 2023 онд 12,558.7 сая төгрөгийн 216 гэрээг байгуулж ажиллажээ.

Гэрээ байгуулсан 239 төсөл, арга хэмжээнээс 237 ажлын гүйцэтгэлд үндэслэн нийт 13,759.3 сая төгрөгийг олгосон байна. Үүнд:

- ✓ *Тайлант онд бүрэн хэрэгжиж дууссан 215 төсөл, арга хэмжээнд нийт 12,354.3 сая төгрөг;*
- ✓ *Он дамжин хэрэгжих 21 төсөл, арга хэмжээнд 1402.3 сая төгрөг;*
- ✓ *Галшар сумын “Мал угаалгын ванн барих” төсөл, арга хэмжээний зураг төслийн зардалд 2.7 сая төгрөг;*

Харин гэрээ байгуулсан Баян-Адарга сумын “Адарга багийн төсвийн засвар”, Бор-Өндөр сумын “Хөл бөмбөгийн талбай” төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй учир гүйцэтгэл олгоогүй байна.

Олгосон санхүүжилтийг гүйцэтгэлийн төрлөөр нь ангилж үзвэл ажлын гүйцэтгэлд 13,149.3 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 33.3 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 54.6 сая төгрөг, зураг төсөвт 336.2 сая төгрөгийг олгосон байна.

Мөн гэрээнд заасан хугацаандаа гүйцэтгээгүй 5 төсөл, арга хэмжээнд 5.4 сая төгрөгийн алдангийг суутган тооцож гүйцэтгэлийг олгон, 14 төсөл, арга хэмжээний чанарын барьцаа болох 180.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээг байгуулахдаа Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6-д заасны дагуу алданги тооцох асуудлыг гэрээнд тусгаагүй, тусгасан боловч гэрээний хугацааг хэтрүүлсэн алдангийг тооцохгүйгээр гүйцэтгэлийг олгож байна.



Аудитын явцад Биндэр суманд 5 төсөл, арга хэмжээнд 2.2 сая төгрөг, Бор-Өндөр суманд 6 төсөл, арга хэмжээнд 24.9 сая төгрөгийн алдангийг тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аудитаар дээрх зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээ.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бага дүнтэй, хэт олон ажилд зарцуулсан нь үр дүнгүй байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 2023 онд 18,912.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 278 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.



Батлагдсан төсөл, арга хэмжээний 239 төсөл, арга хэмжээ нь бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд үүнээс 14,002.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 215 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Харин 2023 онд 2,718.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 21 төсөл, арга хэмжээнд нийт 1,402.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч хүйтний улирлаас шалтгаалан дутуу хэрэгжиж дараа онд шилжсэн байна.

Тус аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлын хүрээнд орон нутагт ажиллах явцад төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн.

Зураг 1. Галшар сумын “Ёслол хүндэтгэлийн өргөөний гадна засвар”



“

Галшар сумын “Ёслол хүндэтгэлийн өргөөний гадна засвар”-ын ажлыг бүрэн гүйцэтгэж, актаар хүлээлгэж өгсөн хэдий ч барилгын дээвэр чанаргүй хийгдсэний улмаас баруун хойд хэсгээрээ хуурсан.

”

Зураг 2. Биндэр сумын “Залуус хөгжлийн төв”

“

Биндэр сумын “Залуус хөгжлийн төв”-ийн барилга нь 2022 онд гэрээ байгуулан хэрэгжиж эхэлснээс хойш 125.8 сая төгрөгийн /90 хувь/ санхүүжилт авсан хэдий ч ашиглалтад бүрэн хүлээлгэж өгөөгүй, гүйцэтгэл дутуу байна.

”



Эдгээр ажлуудад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар үзлэг хийлгэж дүгнэлт гаргуулсан бөгөөд гарсан дүгнэлтийг үнэлж тодорхой хугацаанд алдаа зөрчлийг арилган, төсөл, арга хэмжээг бүрэн дуусгаж хүлээлгэж өгөх албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.



Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Галшар суманд “Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт” төсөл, арга хэмжээг 202.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, 199.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Тухайн ажлын гүйцэтгэлд үндэслэн 2023 онд 91.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч гүйцэтгэгч ажлаа дутуу гүйцэтгэж үлдэгдэл санхүүжилтээ аваагүй байна.



Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс огт хэрэгжээгүй 39 ажил байна.



Үүнээс 35 ажил нь баталсан төсөв хүрээгүй, худалдан авах ажиллагаа зарласан боловч оролцогч оролцоогүй, малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүйгээс энэ орлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.



Галшар сумын “Мал угаалгын ванн барих” ажлын хувьд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 66.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан хэдий ч тухайн гүйцэтгэгч ажлаа огт хэрэгжүүлээгүй байна.



Хэрлэнбаян-Улаан тосгоны 25.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн ОНХС-аас хөрөнгө хуваарилаагүй учир хэрэгжих боломжгүй болсон байна.

Төлөвлөсөн ажлуудаас бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 42.5 хувь буюу 67 ажил нь /Хүснэгт 4-өөс/ орчны тохижилт буюу гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалт, цэцэрлэгт, хүрээлэнгийн тохижилт, наадмын талбайг шинээр барих, тохижуулах, хог ачих тээвэрлэхэд зориулсан тоног төхөөрөмж байна.

Мөн 21.8 хувьд нь шинэ суурьшлын бүсэд цахилгааны шугам татах, зам гүүрний засвар, инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлт зэрэг дэд бүтцийн чиглэлийн 4,119.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Эдгээр нь иргэдийн амьдрах нөхцөл боломжийг дээшлүүлэх, эзэмшиж, өмчилж авсан газрын ашиглалтыг сайжруулах, гадаад, дотоодын аялагчдын тав тухтай зорчих нөхцөлийг сайжруулах зэрэг ач холбогдолтой ажлуудыг хэрэгжүүлсэн гэж үзэхээр байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 321.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Ариутгалын авто дук машин 4
- Мал угаалгын ванн засварлах ажил 6
- Мал тарилгын хашаа 3
- Мал эмнэлэгт вакцин хадгалах хөргүүр, бусад тоног төхөөрөмжид 3 ажил байна.

Эдгээр нь малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай вакциныг хадгалах, малыг вакцинжуулах, ариутгах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд байна.

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 7 суманд 23 худгийг шинээр гаргах, сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь 9,200 га бэлчээрийг усжуулсан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг дүгнэж үзэхэд орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөө үзүүлэх хэмжээний ажлыг төлөвлөж хэрэгжүүлээгүй, бага төсөвт өртөгтэй хэт олон төсөл, арга хэмжээнд хөрөнгийг үр дүнгүй зарцуулж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг үр дүнтэй, үр нөлөөтэй байлгахын тулд төсөл, арга хэмжээний чиг үүргийг үр дүн гарахуйц тодорхой, цөөн тооны чиг үүрэгт хэрэгжүүлдэг байхаар журамд өөрчлөлт хийх шаардлагатай байна.

2.3. Төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Тайлант хугацаанд аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 278 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 214 төсөл, арга хэмжээг зураг төсөл, ажлын даалгавар,



техникийн тодорхойлолтын дагуу бүрэн хэрэгжүүлж актаар хүлээлгэж өгсөн нь анх төлөвлөсөн зорилтод түвшин үр дүнд хүрсэн гэж үзэхээр байна.

ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс сумын төвийн гэрэлтүүлэг, усны машин, ариутгалын авто дук машин, трактор, ковш зэрэг техникийг сумын аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.

Мөн 16 суманд 2,516.8 сая төгрөгийн гэрээгээр 22 гэрэлтүүлгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулж, иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлжээ.

Малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах зорилгоор малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 6 суманд сайн үүлдрийн эцэг мал худалдан авах ажлыг хэрэгжүүлсэн байна. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан эцэг мал худалдан авах ажил тайлант оны 4 дүгээр улиралд хийгдсэн байна.

Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээг ашиглалтгүй үзлээ. Үүнд:

➤ Дархан суманд хийгдсэн Спорт залны зураг төсөв, Баянмөнх сумын шинэ суурьшлын бүсийн жишиг сууцны зураг төсвийг ашиглаагүй байна.

➤ Баян-Овоо, Дэлгэрхаан суманд мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийг худалдан авсан боловч тухайн төхөөрөмжийг ашиглах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаагаас ашиглахгүй байна.

Зураг 3. Баян-Овоо суманд “Хөдөлмөр зуслан”, Дэлгэрхаан суманд “Мал нядалгааны цэг”



- Баян-Овоо суманд “Хөдөлмөр зуслан”, Дэлгэрхаан суманд “Мал нядалгааны цэг”-ийн ажил нь төлөвлөлт, үр дүнг бүрэн тооцохгүй хэрэгжүүлснээс ашиглахгүй байна. Мөн тухайн ажил нь ямар хэмжээний хөрөнгө оруулалтыг оруулснаар бүрэн хүчин чадлаар ашиглах боломжтой болох эсэх нь тодорхойгүй байна.

Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэн ашиглалт хадгалалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.



БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ АЖЛЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд аймаг, сумын ИТХ болон захиргааны байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.

3.1.1. Аймаг, сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2. “Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн аймаг, сумын ИТХ-ын чиг үүргийн хэрэгжилтийг авч үзвэл нийт хэрэгжүүлсэн 239 төсөл арга хэмжээний 30.7 хувь буюу 73 арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлсэн бол 69.3 хувьд нь хяналт хэрэгжүүлээгүй байна. Аймаг, сумын ИТХ-ын 73.7 хувь буюу 14 сумын ИТХ хяналтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Батширээт, Биндэр, Дэлгэрхаан зэрэг 3 сумын ИТХ-аас 35 төсөл, арга хэмжээг бүрэн хамруулан хяналтыг хэрэгжүүлж сумын Засаг даргад зөвлөмж өгч ажилласан байна.

Батноров, Баянмөнх, Баянхутаг, Бор-Өндөр, Галшар, Дадал, Дархан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Хэрлэн зэрэг 11 сумын ИТХ-аас хяналт, шалгалт хийсэн талаар баримт материал ирүүлсэн боловч төсөл арга хэмжээг бүрэн хамруулж хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд 38 төсөл, арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлж, 80 арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Баян-Адарга, Баян-Овоо, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сум, Бэрх, Гурванбаян, Өлзийт тосгон зэрэг 7 сум, тосгоны 55 төсөл арга хэмжээнд ИТХ-аас хяналт хийсэн талаарх баримт материалыг аудитад ирүүлээгүй болно.

Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлсэн 6,738.4 сая төгрөгийн 34 арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн СХДАА Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 дэх “Сангийн яам нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа заавал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авна” гэсэн заалтын дагуу ОНХС-ийн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд 2024 онд хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс 2023 онд “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ”, мөн 9.6, 10.3.4 дэх заалтын дагуу” ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын



хэрэгжилттэй холбоотой хийгдсэн аудит, хяналт шалгалтын тайлан бусад мэдээллийг мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3.1.2. Сумдын ОНХС-ийн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 13,759.3 сая төгрөгийн 239 арга хэмжээг хэрэгжүүлснээс "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам"-ын дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлбэл зохих 9,710.8 сая төгрөгийн 70 арга хэмжээ байна. Үүнээс 7,689.8 сая төгрөгийн 42 арга хэмжээ буюу 60 хувьд нь аймгийн ГХБХБГ-тай гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

Зураг төсөв зохиогч байгууллагатай гэрээ байгуулан аймаг болон Хэрлэн сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд журмын дагуу зохиогчийн хяналтыг хийлгэсэн байна.

Аймгийн ОНХС-ийн 91.0 сая төгрөгийн төсөвтэй 1, 14 сумын ОНХС-ийн 1,930.0 сая төгрөгийн төсөвтэй 27 арга хэмжээнд захиалагчийн хяналтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Дүрслэл 2. Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй ТАХ-ний тоо



Захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй 28 ажлын 14 ажилд нь сумын Засаг даргын захирамж болон ЗДТГ-ын даргын тушаалаар томилсон ажлын хэсэг явцын хяналт тавьсан байна.

Мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгээгүй нь тухайн төсөл арга хэмжээ чанаргүй, зураг төсвийн дагуу гүйцэтгэхгүй байх эрсдэлийг үүсгэж хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй болоход нөлөөлж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг 13 суманд Засаг даргын захирамжаар томилж, 2,682.6 сая төгрөгийн төсөвтэй 69 арга хэмжээнд явцын хяналтыг хэрэгжүүлжээ.



Сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалаар 19 суманд төсөл арга хэмжээг хүлээн авах ажлын хэсгийг томилж, нийт ажлын 53.7 хувь буюу 5,372.8 сая төгрөгийн төсөвтэй 128 төсөл арга хэмжээг актаар хүлээн авч ажилласан байна.

Иймээс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд холбогдох заавар журмын дагуу захиалагчаас тавих хяналтыг сайжруулж хөрөнгийн үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.1.3. Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 92.0 хувьтай байна.

Аймаг болон Дархан, Цэнхэрмандал сумын ОНХС-д тогтоосон 47.2 сая төгрөгийн 3 төлбөрийн акт 100 хувь, аймаг болон Дархан сумын ОНХС-д хүргүүлсэн 2,465.0 сая төгрөгийн 6 албан шаардлага 95 хувьтай биелсэн байна.

Аймаг, сумын Засаг дарга нарт өгсөн 876.3 сая төгрөгийн 13 зөвлөмжийн хэрэгжилт 80.9 хувьтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	47,200	3	47,200	100
Албан шаардлага	6	2,465,000	6	2,465,000	95
Зөвлөмж	13	876,300	13	876,300	80.9
Нийт дүн	22	3,388,500	22	3,388,500	92.0

Албан шаардлагын хэрэгжилтийг авч үзвэл:

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн нэгж, байгууллагууд хийдэггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлагын хэрэгжилт 70 хувьтай, бусад 5 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн.

Аймаг, сумдад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээнд техникийн хяналт, зураг төсөл зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулан гүйцэтгүүлж байх 39.1 хувьтай,

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн систем, Шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв, бүрэн мэдээлж байх 17.4 хувьтай,

Аймаг, сумдын ИТХ-аас тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотой зохион байгуулах зөвлөмжийн хэрэгжилт 26.1 хувьтай хэрэгжүүлсэн бол бусад 10 зөвлөмжийг 87-100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Цаашид дээрх хангалтгүй хэрэгжүүлсэн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.



3.2. ОНХС-ийн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, журмын дагуу иж бүрэн тайлагнах, иргэд, олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх шаардлагатай байна.

3.2.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлэн ажилласан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 21 сум, тосгон “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т ирүүлсэн боловч тайлан нь журмын 9.9 дэх заалтад дурдсан иж бүрдлийг хангаагүй, мэдээллийг бүрэн тайлагнаагүй байна. Үүнд:

➤ *Баян-Адарга сум, Өлзийт тосгон гүйцэтгэсэн арга хэмжээний гэрэл зураггүй, Баян-Адарга, Баянмөнх, Баянхутаг, Бор-Өндөр, Жаргалтхаан, Мөрөн, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумд бий болсон хөрөнгийг өмчлөлд бүртгээснийг баталгаажуулсан баримтыг хавсаргаагүй байна.*

Иймд аймгийн ХОХБТХ-ээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний холбогдох журамд заасан мэдээллийг бүрэн багтаасан тайланг хугацаандаа ирүүлэх талаар сумдын Засаг дарга нарт чиглэл зөвлөмжийг хүргүүлэх шаардлагатай байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 9.9-д заасны дагуу “Хэнтий аймгийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайлан”-г Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.

Гэвч аймгийн ХОХБТХ нь аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн сум бүрээр дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай саналыг боловсруулж, аймгийн Засаг даргад танилцуулж, тодорхой шийдвэр гаргуулна гэсэн журмын 9.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Сумдын Засаг дарга нар ОНХС-ийн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гарган сумын ИТХ-аар хуралд танилцуулж хэлэлцүүлэн ажилласан байна.

3.2.2. Сангийн хөрөнгөөр бий болсон 403.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна.

Хэнтий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 238 дугаар албан бичгээр харьяа байгууллагуудын данс бүртгэлд тусгах талаар сумдын ЗДТГ-т зөвлөмж өгч, жагсаалтыг хүргүүлжээ.

Жилийн эцсийн байдлаар 2023 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 11,979.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 470.1 сая төгрөгийн бараа материал, нийт 12,449.4 сая төгрөгийн хөрөнгийг төрийн байгууллагуудын дансанд орлогоор бүртгэж, 899.1 сая төгрөгийн хөрөнгийг урсгал зардлаар тайлагнасан байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2024 оны 5 дугаар сарын 02-ны 07 тоот тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2,160.9 сая төгрөгийн өртөгтэй 10 төсөл, арга хэмжээний хүрээнд 2023 онд бий болсон цахилгаан дамжуулах агаарын шугамыг төрийн өмчид шилжүүлэхээр шийдвэрлэж,



хэрэгжилтийг 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор ИТХ-ын төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн хорооны хурлаар хэлэлцүүлэхийг ОНӨГ-ын дарга Г.Лхагвахатанд даалгажээ.

ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэж дууссан Баян-Адарга суманд Монгол хатдын өргөөний ариун цэврийн байгууламжийн шугам сүлжээний 15.0 сая, Хэрлэн суманд хийсэн Баатруудын гудамжны Ногоон байгууламж бүхий жишиг гудамжны тохижилтын 388.0 сая, нийт 403.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна. Энэ нь хөрөнгийн үр дүнг бууруулах, хамгаалалт алдагдах, ашиглалтад нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.

Иймд холбогдох журмын дагуу бий болсон хөрөнгийг хариуцагч байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулж, ашиглалтын засвар үйлчилгээг хариуцуулан тавих хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

3.2.3. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг үнэн зөв оруулж, иргэд, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх ажил хангалтгүй байна.

Удирдлагын мэдээллийн системд иргэдийн санал авсан 1885, Иргэдийн нийтийн хурлаас баталсан 1239, ажлын хэсэг эрэмбэлсэн 304, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын баталсан 214 ажлын мэдээллийг тус тус оруулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан 278 хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг оруулахаас 162 арга хэмжээний мэдээллийг бүрэн мэдээлсэн бол 50 арга хэмжээний мэдээллийг дутуу мэдээлсэн байна. Үүнд төсөл арга хэмжээний зарцуулалтын дүн, гүйцэтгэлийн хувь, гүйцэтгэлийн өмнөх, явц, эцсийн фото зураг зэрэг мэдээллийг бүрэн оруулаагүй, хамааралгүй мэдээлэл оруулсан алдаа зөрчил илэрч байна.

Оруулсан мэдээллийн 43.7 хувь нь явцын фото зураггүй, 6 хувь нь гэрээний дүнг зөрүүтэй мэдээлсэн, 35.5 хувь нь төсвийн зарцуулалтын дүн зөрүүтэй, 33.5 хувь нь гүйцэтгэлийн хувь зөрүүтэй, 9.8 хувь нь гүйцэтгэгчийг мэдээлээгүй, 33 хувь нь тендер шалгаруулалтын журмыг мэдээлээгүй байна.

Энэ нь хариуцсан ажилтнууд мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулахгүй, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавихгүй байгаагаас шалтгаалж байна.

Мөн төсөл арга хэмжээний төсвийн зарцуулалтын дүнг дутуу мэдээлж байгаа нь төрийн сангийн удирдлагын цахим системээс татан оруулдаг учир гүйцэтгэгчийн нэр, регистрийн дугаар бүрэн орохгүй байгаатай холбоотой байна.

Харин аймаг, сумын ОНХС-ийн 10,204.3 сая төгрөгийн 66 арга хэмжээний мэдээллийг огт оруулаагүй байна. Үүнд:



Дүрслэл 3. Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл оруулаагүй ТАХ-ний тоо



Удирдлагын мэдээллийн системд төсөл арга хэмжээний мэдээллийг бүрэн мэдээлээгүйгээс иргэд олон нийтэд үнэн зөв мэдээллийг хүргэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБХ орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.3.9-д заасны дагуу нийт 12 мэдээ мэдээллийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд түгээн ажилласан байна.

3.2.4. Шилэн дансны цахим хуудсанд орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг мэдээлэхдээ үнэн зөв, бүрэн мэдээлээгүй зөрчил илэрч байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.9, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 11 дүгээр хавсралтын хүрээнд www.shilendans.gov.mn цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр болон бүтэн жилээр мэдээлэх үүрэгтэй байдаг.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг Хэнтий аймаг, Хэрлэн, Баян-Адарга, Баян-Овоо, Галшар, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Дархан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумд, Гурванбаян, Өлзийт, Хэрлэнбаян-Улаан тосгон ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны цахим хуудсанд цаг тухайд үнэн зөв, бүрэн мэдээлсэн байна.

Харин нь Биндэр, Дэлгэрхаан, Жаргалтхаан сум, Гурванбаян тосгон ОНХС-ийн 82.3 сая төгрөгийн төсөвтэй 9 арга хэмжээний төлөвлөлтийг, 154.6 сая төгрөгийн төсөвтэй 11 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг мэдээлээгүй, Баян-Адарга, Жаргалтхаан, Норовлин сумд үнийн дүнг зөрүүтэй мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1. “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” зарчмыг хангахгүй байна. Үүнд:

➤ **Биндэр 70.4 сая төгрөгийн 8, Дэлгэрхаан 12.0 сая төгрөгийн 1 арга хэмжээний төлөвлөгөөг, Биндэр 50.2 сая төгрөгийн 6, Дэлгэрхаан 12.3 сая төгрөгийн 1, Жаргалтхаан 27.1 сая төгрөгийн 2, Гурванбаян 65.0 сая төгрөгийн 2 арга хэмжээний гүйцэтгэлийг мэдээлээгүй байна.**

Иймд шилэн дансны цахим хуудсанд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тухай бүр бүрэн, үнэн зөв мэдээлээгүйгээс иргэд олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүрэхгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.



ИРГЭДЭЭС АВСАН САНАЛЫН ТАЛААР

Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх санал асуулгыг 13 асуултын хүрээнд иргэд, олон нийтээс цахимаар авахад 279 хүн хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 46.6 хувь нь 36-50 насны хүн, боловсролоор нь авч үзвэл магистр 33, бакалавр 186, бүрэн дунд 59, доктор 1 хүн хамрагджээ. Судалгааны дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Санал асуулгын дүн 1

№	Асуулт	Хариулт				
		Хангалт тай	Хангалт гүй	Сайн	Дунд	Мэдэхгүй
1	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар та хэр мэдээлэлтэй вэ	165	98			16
2	Та Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарт ямар үнэлгээ өгөх вэ		20	96	128	35
3	Танай орон нутагт орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон бүтээн байгуулалт, хөрөнгийн ашиглалтад та ямар үнэлгээ өгөх вэ	104	16		127	32

Хүснэгт 7. Санал асуулгын дүн 2

№	Асуулт	Хариулт			
		Тийм	Үгүй	Сайн мэдэхгүй	Зарим нь
1	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль, тогтоомж, журмыг судалж үзсэн үү ?	139	140		
2	Та 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү ?	181	98		
3	Танай орон нутгийн иргэдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байна уу?	124	16		139
4	Та өөрийн орон нутагт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын хэрэгжилтэд хяналт тавьдаг уу ?	111	168		
5	Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 онд баталсан хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтууд нь орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон уу?	149	9	121	
6	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд одоо мөрдөж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай юу?	34	63	182	

Судалгааны бусад асуудлыг авч үзвэл:

- Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн асуултад 80 хүн Засаг дарга, хороодын хэсгийн ахлагчаас, 19 хүн нэг цэгийн үйлчилгээ, иргэний танхимын ажилтнаас, 112 хүн орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевиз, сошиал, фейсбүүкээс, 28 хүн удирдлагын мэдээллийн системээс мэдээлэл авдаг гэж хариулсан бол 40 хүн буюу 14.3 хувь нь мэдээлэл авдаггүй,
- Орон нутгийн хөгжлийн сангийн "Удирдлагын мэдээллийн системээс ямар төрлийн мэдээлэл авдаг вэ гэсэн асуултад 92 хүн буюу 33 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулжээ.
- Танай орон нутгийн иргэдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байна уу гэсэн асуултад 16 хүн үгүй гэж хариулж, зарим хүн нэн шаардлагатай биш зүйл чанаргүй хөрөнгө оруулалт



хийгддэг, оруулсан саналууд хасагддаг, наадам болохтой холбоотой саналууд оруулсан гэжээ.

4. Та Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарт ямар үнэлгээ өгөх вэ гэсэн асуултад зарим иргэд хариулахдаа шалгарсан газрууд шаардлага хангасан ажил хийхгүй байна, хийсэн ажлууд эвдэрсэн, гэр майхнууд дараастай, олон нийтэд ашиг багатай, хуучин юм эсвэл шаардлага хангахгүй юм найз нөхдөөсөө худалдаж авдаг, хамаарал бүхий этгээдүүд тендер авч ажлыг гүйцэтгэл муутай ёс төдий хийдэг, хяналт сул, хангалтгүй хяналт муутай хийгддэг, жил хүрэхгүй нураад унадаг, ажил хийх хэмжээний мөнгө өгдөггүй, шаардлага хангахгүй, төсөв хүрдэггүй, олон хүнд хувааж амсуулах төдий мөнгө өгдөг, төлөвлөлт муугаас өөр нэг ажил хийхдээ өмнөхөө сүйтгэдэг, чанар муу материалаар хийдэг, чанар муу стандарт бус гэж үзэж байна гэжээ.

Зарим иргэдээс ирсэн саналыг авч үзвэл:

- *Сум, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн томоохон ажилд хөрөнгийг зарцуулж байх;*
- *Төсөл, арга хэмжээгээр засварын ажил хийлгэхгүй байх;*
- *Иргэдийн санал авах үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах;*
- *Хяналтыг эхнээс нь дуустал оролцуулж ажиллуулдаг байх;*
- *Бага хэмжээний мөнгөн дүнтэй ажлуудыг заавал ААН биш бүлгүүдээр хийлгэх;*
- *Ажлын хэсгийн эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХ-аас өөрчилдөг энэ асуудлыг зогсоох;*
- *Иргэний амьдралын чанарт чухал орон зай нийтийн орон сууцны засвар үйлчилгээнд хөрөнгө зарцуулах, хамрах хүрээг өргөтгөх гэсэн саналуудыг өгсөн байна.*

Дээрх санал асуулгаас дүгнэж үзэхэд орон нутгийн хөгжлийн сангийн талаар иргэд олон нийтэд мэдээллийг тухай бүр хүргэдэггүй, хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд тавих хяналт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чанар, ашиглалт хангалтгүй байгаа нь харагдаж байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2024.07.05 № 4/1360
танай _____ -ны № _____ -т


**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлд тусгах саналгүй болно.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Б.ДАРХАНБААТАР

231071051

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлд тусгах саналгүй болно."

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Б.ДАРХАНБААТАР

231071051

ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2024.07.05 № 4/1360
танай _____ -ны № _____ -т



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Аймаг, сумдын Засаг дарга нь ОНХС-д Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4, 60.2.9-д заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөөгүй байна.
- Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.
- Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь ОНХС-ийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг журмын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн боловч зарим сумдын тайлангийн бүрдэл дутуу, үр дүнг нэгтгэн дүгнэлт гаргаж аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.
- Аймаг, сумдын ЗДТГ-ын холбогдох албан хаагчид ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- Сумдын ЗДТГ-ын холбогдох албан хаагчид Шилэн дансны цахим хуудсанд ОНХС-ийн төсөл арга хэмжээний мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлээгүй байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын үр дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 дэх заалтын хүрээнд тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Засаг даргад:

- Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4, 60.2.9-д заасан орлогын эх үүсвэрийг судалж ОНХС-ийн орлогыг нэмж төлөвлөх
- Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх ажлыг зохион байгуулах
- Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3 дахь хэсгийг хэрэгжүүлэн ажиллах
- Аймаг, сумдын ОНХС хариуцсан мэргэжилтнүүд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, бүрэн оруулах, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах
- Сумдын шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий албан хаагчид ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж ажиллах

ҮАГ-т санал:

- “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.2, 4.4-т заасан чиг үүргийг орон нутгийн хөгжилд бодит үр нөлөө үзүүлэх, үр дүн гарахуйц тодорхой, цөөн тооны чиг үүрэгт хэрэгжүүлдэг байхаар журамд өөрчлөлт оруулах
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэх зарим журам хүчингүй болж шинэчлэгдсэн учир энэ журамд холбогдох өөрчлөлтийг оруулах
- ОНХС-ийн хөрөнгөөр Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл бүхий төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг заавал хийдэг байх зохицуулалтыг журамд тусгах



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 07 дугаар сарын 05

Дугаар А/26

Чингис хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай 1

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МҮЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга (Г.Хэрлэнчулуун), аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав) нарт, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав), сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ахлах аудитор Ц.Билэгсайхан/-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232410045

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn